



Хямралын үед хүүхэд, залуучуудын нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сайн сайхан байдлыг хангах

Оршил

КОВИД-19 тахал нь тусгаарлах, сургуулиудыг хаах, хоорондын зай барих, дадал болсон орчныг алдагдуулах зэргээр нөлөө үзүүлж байна. Хөдөлгөөнийг хязгаарлаж хэвшмэл дэглэмийг тасалдуулан нийгмийн харилцааг хүмхад хүргэж, уламжлалт суралцах аргуудыг зогсоох нь залуучууд, тэдний гэр бүл, олон нийтийн дунд дарамт, шахалт, сэтгэлийн түгшүүрийг нэмэгдүүлж байна.

Эцэг эх, насанд хүрсэн асран хүмүүжүүлэгчид ажил хийн нийгмийн үүрэг хариуцлагаа ухамсарлахын зэрэгцээ гэр бүлийн гишүүддээ анхаарал халамж тавих, хувь хүний сайн сайхан байдлаа хадгалах, гэрээр суралцах бэрхшээлүүдийг даван туулж байна. Багш нар урьд өмнө түршиж байгаагүй шинэ заах аргуудад хурдан дасан зохицох шаардлагатай болж байна. Улсын шалгалтуудыг цуцалж, тусгаарлалт, тодорхойгүй байдалтай тулгарч байгаа залуучууд боловсролдоо санаа зовниж байна. Нэн тэргүүн ээлжинд орлогоо боддог ядуу өрхийн хүүхдүүдийг гэрийн сургалтад үлдээх эсвэл тэдэнд өөр үүрэг даалгавар өгөх асуудал тулгарч байна.

Цар тахлаас үүдэлтэй стресс, сэтгэлийн түгшүүр нь мэдээллийн хурдацтай эргэлтээс үүддэг бөгөөд үнэн, худал ямар ч мэдээллүүд сенсацлагч хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагддаг. Энэ нь аюулгүй байдлыг нэмэгдүүлээд зогсохгүй хүлцэнгүй байдал, арьс өнгөөр ялгаварлан гадуурхалт, ксенофоби, үзэн ядалтаас үүссэн гэмт хэргийн тархалтын үндэс суурь болдог.

КОВИД-19 тахлаас үүдэлтэй нийгмийн болон сэтгэл хөдлөлийн тогтворгүй, айдас түгшүүртэй байдлыг арилгахын тулд гэр бүл, нийгмийн бүлгүүд аливааг даван туулах чадвар, сэтгэл хөдлөлийн тэсвэр хатуужилтай байх шаардлагатай.

Нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн үр чадвар гэдэг нь хүүхэд, залуучууд, эцэг эхчүүд, багш нарт эрүүл бөгөөд эерэг байх, сэтгэл хөдлөлөө удирдах, ухаалгаар оролцоогоо хангах, нийгэмд ээлтэй шинж чанарыг илэрхийлэх болон өдөр тутмын саад бэрхшээлийг даван туулахад шаардлага болохуйц үндэслэл сайтай, нотолгоонд суурилсан дадал туршлага юм.

Сэдэв болон холбогдох асуудлуудыг тодорхойлох

Цунами, иргэний үймээн самуун эсвэл КОВИД-19 гэх мэт аливаа хямрал нь үймээн, стресс, түгшүүр, уур хилэн, айдас зэрэг сөрөг сэтгэл хөдлөлийг хүчтэй өдөөдөг. Нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сургалтын (SEL) үр чадварыг бий болгосноор стресстэй нөхцөл байдалд тайван байж, сэтгэлийн хөдөлгөөнөө удирдаж хандах зан төлөвийг бий болгодог төдийгүй илүү мэдээлжсэн шийдвэр, үйлдэл гаргах шүүмжлэлт сэтгэлгээг бэхжүүлж өгдөг (Арслан ба Демирташ, 2016). Айдас, стресс нь эрүүл мэнд болон суралцах чадварт сөргөөр нөлөөлдөг (Иммордино Ян, Дамасио, 2007). Аливаа насны суралцагчдын суралцахууд стресс болон итгэлгүй байдал нөлөөлдөг. Хүний тархи нийгэмтэйгээ холбогдож, сэтгэл хөдлөлийн хувьд аюулгүй байх үедээ л эрдэм шинжилгээний ажилд анхаарлаа төвлөрүүлж суралцаж эхэлдэг.

Өмнөх туршлага, өнөөгийн хямралаас олж авсан сургамж

Судалгаанаас харахад Нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сургалтыг бусад сургалтын адилаар заах боломжтой. Хямралын үед насанд хүрэгчид, эцэг эхчүүд нь багшийн үүргийг гүйцэтгэж хүүхэд, залуучуудад Нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сургалтын чадварыг бий болгох боломжтой. Гэр бүлийн хүрээнд тухайн хямралын талаар урлаг, боловсролоор дамжуулан заах боломжтой юм. Тухайлбал, хүүхдүүд байгалиас заяасан энэрэнгүй шинж чанартай байдаг нь судалгаагаар нотлогдсон байдаг. (Уорнекен, 2013). Иймээс байгалиас заяасан энэрэнгүй хүсэл тэмүүллийг өдөөдөг үйл ажиллагааг хөхиүлэн дэмжиж болно. Иймэрхүү эерэг зан авир нь айдас, уур уцаар гэх мэт сөрөг сэтгэл хөдлөлийг итгэл, найдвар зэрэг эерэг сэтгэл хөдлөл рүү хөрвүүлэхэд тусалдаг тархин дахь эргэлтийг идэвхжүүлээд зогсохгүй уур уцаартай үед өөрсдийгөө тайвшруулж, зөрчилдөөнийг шийдвэрлэж, ёс зүйтэй, аюулгүй сонголтуудыг хийхэд тусалдаг (Виллард болон бусад, 2019).

Нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сургалтын үр чадварыг хүн бүрд цаг үргэлж эзэмшүүлэх шаардлагатай. Хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид бүгд Нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сургалтын үр чадвараас ашиг тус хүртэх боломжтой. Эдгээр нь зан авирын асуудалтай хүүхэд, залуучуудад зориулсан эмчилгээ биш бөгөөд насан туршдаа суралцах, өсч хөгжихийн нэгээхэн хэсэг юм. Ялангуяа хүүхэд, өсвөр насныхны хувьд Нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сургалтын үр чадварын бэлтгэл нь тэдэнд өөрийгөө бүрэн төгс, тодорхой илэрхийлэх, үе тэнгийнхэн болон насанд хүрэгчидтэй илүү сайн, эрүүл харилцаа тогтоон илүү холбоотой байх боломжийг олгодог.

Нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сургалт нь суралцахуйн үзүүлэлт, оюутны чадамжийн цогц хөгжилтэй нягт холбоотой юм. Сургалтын хөтөлбөрт гүнзгий нэвтрүүлсэн Нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сургалтын үр чадвар нь сургалтын гүйцэтгэл нэмэгдсэнтэй шууд хамааралтай байдаг (Зинс, Вайсберг, Ванг, Уолберг, 2004). Хэвлэл мэдээлэл,

дүрслэх урлаг, театр, бүжиг, хөгжим сурах нь хүүхэд, залуучуудын бүтээлч хүмүүнлэгийн туршлага, гүнзгий, урт хугацааны үр чадварыг хөгжүүлдэг тул маш их ач тустай байдаг.

Нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сургалтын үр чадвар нь эдийн засгийг сайжруулдаг. Боловсролын системд Нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сургалт дутагдалтай байгаа нь эдийн засгийн бүтээмжийн алдагдалд хүргэж болзошгүй бөгөөд үндэсний нийт орлогын 29 хувийг эзлэх боломжтой юм (Дураяаппа ба Сэти, 2020).

Хямралын үе дэх Нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сургалт. Хямралд өртсөн орнуудын туршлагаас харахад нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн үр чадварыг сайн эзэмшсэн, тухайн үр чадварт суралцах боломжийг бий болгож, аюулгүй суралцах орчноор хангаж, сэтгэл санааны гэмтлээс эдгэрч, энгийн амьдралд буцаж ороход тусалдаг эцэг эх, асран хамгаалагч, багш нартайгаа хүүхдүүд эерэг харилцаатай байх нөхцөлд стресс, сэтгэлийн хямралын сөрөг нөлөөг багасгах боломжтой байдаг байна (Онцгой байдлын үеийн боловсролын салбар дундын сүлжээ, 2018).

Бодлого, хөтөлбөр зохицуулалтыг төлөвлөхтэй холбоотой гол санаа, практик зөвлөмж

Бодлого боловсруулагч / засгийн газрын байгууллагуудад: – КОВИД-19 болон түүний тархалтаас хэрхэн сэргийлэх, нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн үр чадварыг хэрхэн бий болгох талаар найдвартай, нотолгоонд суурилсан мэдээллийг суралцаж буй бүх хүмүүст өгөх шаардлагатай. Багш, суралцагчид болон тэдний гэр бүлийнхний итгэл үнэмшил, хяналтыг эргэн сэргээхийн тулд хэрхэн эрүүл байх талаар энгийн бөгөөд бодит мэдээллээр хангаж цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тэдэнд өгөх хэрэгтэй. Телевиз, радио, хөдөлгөөнт сургалтын платформ болон бусад хэрэгслийг ашиглан нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн үр чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн мэдлэгийг эзэмшүүлэх зорилгоор хүүхэд, залуучуудтай ажилладаг эцэг эх, боловсрол олгогч нарыг дэмжин орчинд нь тохирсон нөөцөөр хангах шаардлагатай.

Багш нарыг анхааран дэмжиж, багшийн нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сургалтыг чухалчлах – Тусгаарлалтын үед зайн сургалтын горимыг хөгжүүлэх, ашиглахад багшийн мэргэжлийн хөгжлийн нэг хэсэг болох нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сургалтад анхаарал хандуулах хэрэгтэй. Хөгжилтэй, үр өгөөжтэй, олон талт, анхаарал татахуйц, түршилт, гүйцэтгэлд суурилсан дижитал сургалтын шийдлүүдийг хэрэглэхийн тулд багш нарт МХХТ-ийн үр чадварыг эзэмшүүлэх, ашиглах боломжийг нь олгох хэрэгтэй. (Эх сурвалжийн жишээ: <https://mgiep.unesco.org/global-citizenship>).

Хувь хүний болон олон нийтийн тэсвэр хатуужилтай байдлыг дэмжих гол санааг түгээх зорилгоор дижитал хэвлэл мэдээлэл, радио, телевизийн хамрах хүрээг бэхжүүлэх – Хямралын үед зайн сургалтыг явуулж буй хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хандаж хүлээцтэй байдлыг хадгалах, харилцан дэмжлэг үзүүлэх, энэрэнгүй сэтгэлийг дэмжих уриалгууд гаргаж бусад орны нөхцөл байдалтай ижил байгааг харуулах тал дээр анхаарах хэрэгтэй.

Онцгой байдал, хямралд нэрвэгдсэн нөхцөл байдлын үед сэтгэлзүйн тусламжийг нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сургалттай холбох – Хөндлөнгийн оролцооны шаардлагатай үнэлгээг хийх, сургалтын хөтөлбөр, заах, суралцах арга барилыг сургууль хаагдсан болон гэрийн тусгаарлалтын үеийн нөхцөл байдалд шилжүүлэх, шинээр гарч ирж буй болон хурдан өөрчлөгдөж буй асуудлыг шийдвэрлэхэд агуулгыг тохируулах шаардлагатай. Өөрсдөө сайн нөхцөл байдалд байгаа, хүүхдэд эрүүл зан төлөвийг үлгэрлэж чадахуйц насанд хүрэгчдээр дамжуулан нийгмийн болон сэтгэл хөдлөлийн сургалтыг явуулах хэрэгтэй. Онцгой байдлын үед ихэвчлэн тохиолддог жендэрт суурилсан болон гэр бүлийн (бэлгийн) хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг бууруулах, урьдчилсан сэргийлэх зорилгоор жендэр, нийгмийн тэгш хамруулалтыг анхаарах хэрэгтэй.

Урт хугацаанд:

Нийгмийн болон сэтгэл хөдлөлийн сургалтыг боловсролын бүх түвшинд бүхий л хэлбэрээр (албан болон албан бус) нэвтрүүлэхийг сурталчлах – Албан боловсролын бага, анхан, дунд шатны хөтөлбөрт нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сургалтыг илүү хамарсан байдлаар нэвтрүүлэх шаардлагатай. Нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сургалттай холбоотой чадамжийг чухалчилж, сургуулийн нийгэм, сэтгэлзүйн эерэг орчны хүрээнд сургалтын хөтөлбөрийн болон сургалтын хөтөлбөрөөс гадуурх хөгжлийн төлөө хангалттай хугацаа зарцуулан үндсэн сургалтын нэг хэмээн үзэх хэрэгтэй. *Нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сургалтын үр дүнтэй хөтөлбөрүүд* нь хүний эрхэд суурилсан, шинжлэх ухааны үнэн зөв, нотолгоонд түшиглэсэн, оролцоог хангасан, тэгш хамруулсан, жендэрийн мэдрэмжтэй, соёлын хувьд тохиромжтой, тодорхой насны хүмүүст тохируулсан байдаг. Тэд хямралын үед гарч буй нийгмийн хор хөнөөлтэй хэм хэмжээ, дадлыг өөрчлөх, жендэрийн тэгш оролцоог хангах чадамжтай. Нийгмийн болон сэтгэл хөдлөлийн сургалтын үр дүнтэй хөтөлбөрүүд нь сургууль, гэр бүл, нийгэм, хэвлэл мэдээллийн хэрэгслийг хамарсан танхимын гадуурх *том экосистемийн нэг хэсэг* байх ёстой (ОРЕАЛК/ЮНЕСКО болон Fundación Súmate (2020 он)).

Нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сургалтын заавар, дадлыг багш нарт бий болгох – Стрессийг арилгах, анги танхимын орчинд нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн чадамжийг нэмэгдүүлэх зорилгоор Нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сургалтыг багш бэлтгэх болон багшийн мэргэжил дээшлүүлэх, мөн одоогийн боловсрол, мэргэжлийн хөгжлийн хөтөлбөрт тусгах шаардлагатай. Багш нарын сайн сайхан байдлыг дэмжих, сэтгэлзүйн хямралыг бууруулах, анги танхимын харилцааг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сургалтын үр чадварыг эзэмших цаг, боломжийг олгоход сургуулийн удирдлагууд анхаарах шаардлагатай (Женнингс, П.А. (2019 он), Женнингс, П. А., Грийнберг, М. Т. (2009 он)). Тасралтгүй сургалт, сайжруулалтыг дэмжихийн тулд нэг сургуулийн болон өөр өөр сургуулийн багш нарын хооронд туршлага судлах ажлыг сурталчлах хэрэгтэй.

Боловсролын байгууллага, сургууль, багш, эцэг эхчүүд, залуучуудад зориулсан нэмэлт удирдамж

Арга зүйд тасралтгүй суралцах, харилцан дэмжлэг үзүүлж сайн сайхан байдлаа дээшлүүлэх зорилгоор багш хоорондын болон багш нартай *харилцах харилцаа холбоо, сүлжээг дэмжээрэй*.

Эрүүл хооллох дадал зуршил, тогтмол дасгал сургуулилалт, унтлагын зөв цаг гэх мэт *эрүүл мэнд, сэтгэлгээ, эелдэг зан үйлийг дэмжээрэй*. Хөгжөөнт эсвэл амрах цагийг багтаасан уян хатан боловч зохион байгуулалттай өдөр тутмын дэглэмийг дагаж мөрдөөрэй. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих нь нэн чухал зүйл юм. Шаардлагатай бол сэтгэлгээний дадлыг хэвшүүлэх нь зүйтэй. Сайхан сэтгэл, энэрэнгүй зан нь ач тустай төдийгүй анхаарал сарниулж, эерэг бодлыг бий болгодог. Эх сурвалжийн жишээ: ЮНЕСКО, Махатма Гандигийн нэрэмжит энх тайван, тогтвортой хөгжлийн боловсролын хүрээлэнгийн аян #KindnessMatters (<https://mgiep.unesco.org/kindness>; Стресс ба тэмцэл); Буба ба Зазагийн бичлэгийн цувралууд; ABC-ээс гаргасан найрсаг байдлын цувралуудыг агуулсан Смешарикигийн бичлэгүүд (орос хэл дээр).

Сайн сайхан байдлыг дэмжихийн тулд урлаг, соёл, тоглоомын үнэ цэнийг онцлоорой– Тоглоом нь суралцах үйл явц мөн бөгөөд бүтээлч байдал, хөдөлгөгч үр чадварыг хөгжүүлэх, шийдвэр гаргахад тусалдаг. Энэ нь сэтгэлийн түгшүүрийг бууруулж, сэтгэл хөдлөлийг сайжруулдаг. Харилцаа холбоо, хүмүүс хоорондын харилцааны үр чадвар төдийгүй төвлөрөл, эрсдэл даах чадвар гэх мэт танин мэдэхүйн хөгжлийг дэмжих үүднээс хөгжим, бүжиг, зураг гэх мэт зүйлсийг ашиглаарай. Эцэг эх, сурган хүмүүжүүлэгчид сэтгэл хөдлөлийн нэр томъёог бий болгох үүднээс хөгжим ашиглах боломжтой (Наврот, 2003 он). (Эх сурвалж: #KeepMakingArt: КОВИД-19 хямрал нь хүүхэд, залуучууд, эцэг эх, уран бүтээлчдийн дунд итгэл найдвар, нэгдлийг нэмэгдүүлэх зорилгоор урлагийн багш нарын дунд дэлхий нийтийн хөдөлгөөнийг өрнүүлсэн. <https://creative-generation.org/blog-1/keepmakingart-a-campaign-toinspire-hope-and-connection>)

Өсвөр үеийнхний нийгмийн харилцааг дэмжиж, онлайн дахь хариуцлагатай зан төлөвийг бий болгоорой – Нийгмийн цахим сүлжээ болон зай баримтлах аюулгүй бусад аргаар өсвөр үеийнхнийг найз нөхөдтэйгээ холбоотой байхад туслаарай. Энэ боломжийг ашиглан дижитал орон зайн аюулгүй байдал, дижитал чадварыг хөгжүүлэх боломжийг тэдэнд сануулаарай. (Эх сурвалж: Фэйсбүүкээс Боловсролын технологийн олон улсын нийгэмлэг болон ЮНЕСКО-ийн Боловсролын мэдээллийн технологийн хүрээлэнтэй хамтран гаргасан “Дижитал руу шилж”; Өөрийн түүхээ хуваалцаарай: ЮНЕСКО-ийн Холбоот сургуулиудын сүлжээ нь #LearningNeverStops кампанит ажлынхаа хүрээд хүмүүсийн түүхүүдийг цуглуулж хуваалцаж байна. <https://en.unesco.org/covid19/educationresponse/learningneverstops/>)

Сургалтад тоглоом, аудио хэрэгслүүдийг ашиглаарай – Нийгэм, сэтгэл хөдлөл, эрдэм шинжилгээний сургалтыг сурталчилдаг онлайн болон бусад тоглоомуудыг хүүхдүүдэд танилцуулаарай. Гэрийн нөхцөлд эрдэм шинжилгээний үр чадвараар нь дасгал ажил хийлгэж болно. Жишээлбэл, хоолны жорыг тооцоолохдоо математикийг ашиглах гэх мэт. Хамтдаа хоол хийнгээ бүтэлгүйтсэн болон амжилттай болсон хоолны жороо хуваалцаарай. Ном зохиогчийн дуу оруулсан богино өгүүллэг, үлгэр, хөгжим гэх мэт аудио нөөцийг ашиглаарай. Эх сурвалжийн жишээ: UNESCOMGIEP FramerSpace.com

Залуустай илэн далангүй, нээлттэй ярилцаарай – Нээлттэй мэтгэлцээн, шүүмжлэлт сэтгэлгээг дэмжээрэй. Суралцагчдыг шинжлэх ухааны батлагдсан эх сурвалжид тулгуурлан КОВИД-19 болон үүнтэй холбоотой цуурхлын тухай (Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын гарын авлагаас харах боломжтой) виртуал болон бусад мэтгэлцээн зохион байгуулахыг уриалаарай. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын цахим хуудаснаас жишээ үзэх боломжтой. Боломжтой бол сургуулийн сүлжээнд тулгуурлан бусад орны үе тэнгийнхэнтэй виртуалаар харилцахыг хөхиүлэн дэмжээрэй. Эх сурвалж: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Асуулт, хариултын хуудас.

Эх сурвалж

Өдөр тутмын ариун цавиур:

“КОВИД-19” халдвараас сэргийлэн гараа угаах зааврууд (ЮНИСЕФ) <https://www.unicef.org/coronavirus/everything-you-need-know-about-washing-your-hands-protect-against-coronavirus-covid-19>

Эцэг эхчүүдэд зориулсан зөвлөмжүүд:

“КОВИД-19” халдварын үеэр хүүхэд өсгөх (WHO) <https://www.who.int/emergencies/diseases/novel-coronavirus-2019/advice-for-public/healthy-parenting>

“КОВИД-19” халдварын үеэр хүүхэд өсгөх зөвлөмжүүд (ЮНИСЕФ) <https://www.unicef.org/coronavirus/covid-19-parenting-tips>

Хүүхэд багачууд болон “КОВИД-19” тахал (COVID-19): Хичээл сургуулийн үеэр хүүхдүүдийг эрсдэлээс сэргийлэх зөвлөмжүүд (CDC) <https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/prepare/children.html>

Сэтгэл зүйн эрүүл мэнд:

Хүүхэд багачуудад “КОВИД-19” тахал өвчнөөс үүдэх стресс, сэтгэл зүйн хохирлыг даван туулахад нь туслах (WHO) https://www.who.int/docs/default-source/coronaviruse/helping-children-cope-with-stress-print.pdf?sfvrsn=f3a063ff_2

Өсвөр насныхан өөрсдийн сэтгэл зүйн эрүүл мэндийг “КОВИД-19” халдвараас хамгаалах (ЮНИСЕФ) <https://www.unicef.org/coronavirus/how-teenagers-can-protect-their-mental-health-during-coronavirus-covid-19>

Карантинаас үүдэх сэтгэл зүйн хор нөлөө бөгөөд үүнийг хэрхэн багасгах (Lancet)

[https://www.thelancet.com/journals/lancet/article/PIIS0140-6736\(20\)30460-8/fulltext](https://www.thelancet.com/journals/lancet/article/PIIS0140-6736(20)30460-8/fulltext)

Хүүхдэд ээлтэй эрүүл мэндийн мэдээллүүд:

Хүүхдэд ээлтэй мэдээллийн сайтүүд (Interagency Network for Education in Emergencies)

<https://inee.org/collections/coronavirus-covid-19/child-friendly>

Эрүүл мэндийн байдлыг урьдчилан сэргийлэх:

“КОВИД-19” тахлын үед “ДОХ” өвчин туссан хүмүүс зайлшгүй мэдэх ёстой зүйлс (UNAIDS)

https://www.unaids.org/en/20200317_covid19_hiv

Эрүүл бие галбирыг хадгалах:

Карантины үеэр дасгал хөдөлгөөн идэвхтэй хийх (WHO) <http://www.euro.who.int/en/health-topics/health-emergencies/coronavirus-covid-19/novel-coronavirus-2019-ncov-technical-guidance/stay-physically-active-during-self-quarantine>

Хүйсийн бэлгийн хүчирхийлэл:

Хүйсийн бэлгийн хүчирхийллийн зохицуулалт болон “КОВИД-19” тахал (GBV AoR Helpdesk)

<https://gbvguidelines.org/wp/wp-content/uploads/2020/03/guidance-on-gbv-case-management-in-the-face-of-covid-19-outbreak-final-draft.pdf>

Бага насны хүүхдийг хамгалах:

Бага насны хүүдүүдийг “КОВИД-19” тахлын аюулаас сэргийлэх (The Alliance for Child Protection in Humanitarian Action) <https://www.end-violence.org/sites/default/files/paragraphs/download/The%20Alliance%20COVID%2019%20Brief%20Version%201%20%28006%29.pdf>

ЮНЕСКО-ийн Боловсролын салбарын онцлох асуудал

ЮНЕСКО-ийн Боловсролын салбарын онцлох асуудалд КОВИД-19 цар тахлын эсрэг Боловсролын хариу арга хэмжээтэй холбоотой гол сэдвүүдийг хөндөнө. Үүнд сургууль хаагдсантай холбоотой гарсан үр нөлөөг бууруулах хүчин чармайлтын хүрээнд сайн түршлага бүхий баримт, практик зөвлөмж, агуулга тус бүрийн гол эх сурвалж, холбоосыг багтаасан.

Онцлох асуудал нь дараах үндсэн есөн агуулгын хүрээнд хэд хэдэн асуудлыг хамарна. Үүнд: Эрүүл мэнд ба сайн сайхан байдал; Суралцахуй болон багшлахуйн тасралтгүй байдал; Жендэрийн тэгш боломж ба тэгш байдал; Багшлахуй ба суралцахуй; Дээд боловсрол ба Техник мэргэжлийн боловсрол, сургалт; Боловсрол ба соёл; Боловсролын бодлого, төлөвлөлт; Эмзэг бүлгийн хүн ам; Дэлхийн иргэний боловсрол ба Тогтвортой хөгжлийн боловсрол зэрэг орно. Эдгээр асуудлыг ЮНЕСКО-ийн боловсролын мэргэжил нэгт нөхдүүд хамтран бэлтгэсэн юм. Энд дурдсан сэдвийг ЮНЕСКО-ийн Эрүүл мэнд, боловсролын хэлтэс, Боловсролын мэдээллийн технологийн хүрээлэнгээс боловсруулав.

Бидэнтэй хамт байгаарай

ЮНЕСКО-ийн хариу арга хэмжээ



COVID19taskforce@unesco.org



<https://en.unesco.org/covid19/educationresponse>



@UNESCO



@UNESCO